



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2007 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 148

Улаанбаатар

Гадаадад суралцуулах тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 52 дугаар тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам", Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт Сургалтын төрийн сангийн зээлээр өөрийн захиалгаар хүн суралцуулах эрх бүхий байгууллагын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Банди овогтой Ариунчимэгийг Сангийн яамны захиалгаар АНУ-ын Стрээр их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Ичинхорлоо овогтой Жаргалзаяабямбыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар АНУ-ын Вирджиния Олон улсын их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Болдбаатар овогтой Билгүүнийг Үйлдвэр, худалдааны яамны захиалгаар АНУ-ын Вирджиния Олон улсын их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр тус тус 2007-2008 оны хичээлийн жилээс 2 жилийн хугацаагаар Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



Ө.Энхтүвшин

Ө.ЭНХТҮВШИН

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 52 дугаар тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.